



ОРХОН АЙМГИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ

2025 оны 03 дугаар сарын 24

Дугаар 02/16

Баян-Өндөр сум

Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын
хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр
батлах тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 20.1.5 дахь заалт, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.6 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3 дахь хэсгийг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хавсралтаар баталсугай.

2.Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг дарга (Б.Зоригтбаяр)-т даалгасугай. Үүнд:

2.1.Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг баталж, хэрэгжүүлэх;

2.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг жил бүрийн орон нутгийн төсөв, бусад эх үүсвэрт тусган батлуулах;

2.3.Хөтөлбөрийн биелэлтийг жил бүрийн I улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанд тайлагнаж дүгнүүлэх;

ДАРГА



Д.МӨНХБАТ

6125010005

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн Ээлжит II хуралдааны 03/16 дугаар тогтоолын хавсралт

“ХҮН АМЫН БҮЛГҮҮД, НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨР” (2025-2028)

НЭГ.ХӨТӨЛБӨРИЙН ҮНДЭСЛЭЛ

Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах үүднээс хүн амын бүлгүүд болон нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн асуудлыг шийдвэрлэх “Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөр (2025-2028)”-ийг боловсруулсан.

Төрийн үйлчилгээг иргэдэд тэр дундаа хүн амын бүлгүүдэд тэгш, чанартай, хүртээмжтэй хүргэх үүднээс иргэдэд үйлчлэх үйлчилгээг шинэ түвшинд гаргах, ур чадвартай ажилтан, албан хаагчдыг бэлтгэх хэрэгцээ, шаардлага нийгмийн салбарт тулгарч байна.

Хөтөлбөрийг боловсруулахдаа Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.6 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа 2050” урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний зорилт 2.1, 2.2, 2.3, 2.6.13, 2.6.16, 3.1, 3.3, 3.5, 3.5.13 дахь хэсэг, 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн 1.4.2.5, 2.1.1.4, 2.1.1.5, 2.1.1.6, 2.1.1.12, 2.1.1.14, 2.1.1.15, 2.1.1.16, 2.1.1.17, 2.1.1.18, 2.1.1.19, 2.1.1.20, 2.1.1.21, 2.1.1.27, 2.1.1.28, 2.1.1.29, 2.2.3, 2.3.4 дэх заалтууд, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн “Аймгийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 03/15 дугаар тогтоолын 2.1, 2.1.1.2, 2.1.1.6, 2.2, 2.3, 2.4, 2.4.1.7, 2.4.1.9, 2.5, 2.5.1.5, 3.7.1.13, 4.1.1.3 дахь заалтууд зэрэг бодлогын баримт бичгүүдийг үндэслэл болгосон бөгөөд хүн амын бүлгүүд болон нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах гэсэн үндсэн 2 зорилтыг хэрэгжүүлж, салбаруудын хамтын ажиллагаагаар хөгжлийг дэмжинэ гэсэн үндсэн агуулгыг багтаасан болно.

ХОЁР.ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1.ХҮН АМЫН БҮЛГҮҮД:

Хүүхэд, гэр бүл: Орхон аймгийн 30.3 мянган өрх, гэр бүлд 105.9 мянган хүн амьдарч, хүн амын 51 хувийг эмэгтэйчүүд, 32.8 хувийг 0-15 насны хүүхэд, 57.0 хувийг 16-59 насны хөдөлмөрийн насныхан, 10.2 хувийг 60 ба түүнээс дээш насны ахмадууд эзэлж байна. 2020 онтой харьцуулахад өрхийн тоо 6.2 хувь, хүн амын тоо 0.5 хувь, хүүхдийн тоо 1.5 хувь, ахмад настны тоо 31.3 хувиар тус тус өссөн бол хөдөлмөрийн насны хүн амын тоо 4.0 хувиар, 16-34 насны залуучуудын тоо 11.5 хувиар, төрсөн хүүхэд 25.0 хувиар тус тус буурсан. Төрсөн хүүхдийн 50.3 хувь нь эмэгтэй хүүхэд байна.

Өнгөрсөн онтой харьцуулахад бүтэн өнчин хүүхэд 6.6 хувиар, гэрлэлт 12.8 хувиар, цуцлалт 6.6 хувиар тус тус буурсан бол, хагас өнчин хүүхдийн тоо 33.7

хувиар өссөн байна. Гэрлэлт цуцлуулж буй хугацааг харахад 10-19 жилийн хамтын амьдралын түүхтэй гэр бүлийн цуцлалт хамгийн өндөр буюу 44.9 хувийг эзэлж байна.

2-5 насны нийт хүүхдийн 98.1 хувь нь сургуулийн өмнөх боловсролд, 6-17 насны нийт хүүхдийн 97.0 хувь нь ерөнхий боловсролын сургуульд хамрагдаж, 2020 онтой харьцуулахад сургуулийн өмнөх боловсролд хамрагдалтын хувь 7.0 пунктээр өссөн бол, ерөнхий боловсролд хамрагдалтын хувь 2.1 пунктээр буурсан.

Аймгийн хэмжээнд нялхсын эндэгдлийн 20 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 9.9 промилл байна. Нялхсын эндэгдлийг шалтгаанаар авч үзвэл пренатал үеийн эмгэг 80.0 хувийг, осол гэмтэл, гаднын шалтгаант эндэгдэл 10.0 хувийг тус тус эзэлж байна. Пренатал эндэгдлийн түвшин өмнөх оноос 4.3 промиллоор өссөн нь улсын дунджаас 2.5 промиллоор өндөр байна. Эрт илрүүлэг, үзлэгт хамрагдсан нийт хүн амын 48.2 хувь нь 0-17 насны хүүхдүүд байна.

Хүүхэд оролцсон гэмт хэрэг өнгөрсөн оноос 37.5 хувиар буурсан бол, гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэрэг 50.0 хувиар өссөн. Хүүхдийн тусламжийн 108 утсанд 279 дуудлага ирсэн нь 2020 онтой харьцуулахад 51.0 хувиар өсөж, гэр бүлийн хүчирхийлэл зөрчлийн хохирогчийн 70.4 хувь нь эмэгтэйчүүд байна. Нийгэмд гарч байгаа хүүхдийн эсрэг хүчирхийллийн 80 гаруй хувь нь гэр бүлийн орчинд эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зүгээс үйлдэгдэж, түр хамгаалах байраар үйлчлүүлэгчдийн 80.0 хувийг 0-18 насны хүүхэд эзэлж байна.

Хохирогчид үйлчлэх түр хамгаалах зориулалтын байр байхгүйгээс 2020 оноос эхлэн орон сууцны гурван өрөө байрыг түр хамгаалах байраар ашиглаж байна. Улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 2020 онд “Түр хамгаалах байр”-ны барилгын ажлыг эхлүүлсэн ба өнөөдрийн байдлаар 79.0 хувийн гүйцэтгэлтэй байна.

Гэр бүлийн боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийг дэмжих, үр хүүхдээ асран хамгаалахад эцэг, эхийн жигд оролцоог хангах, хүн амын бүлгийн нийгмийн халамж, хамгааллын арга хэмжээг гэр бүлд суурилж хүргэх, гэр бүлд зориулсан цогц үйлчилгээг бий болгох, гэр бүлийн гишүүнийг хүчирхийлэх, эрхийг нь зөрчих явдлыг тууштай бууруулах, зан үйлийн эерэг орчин бүрдүүлэх, гэр бүлийн асуудлаар мэргэжилтнүүдийг мэргэшүүлж ажиллуулах болон шинээр жирэмсний хяналтад орсон эх бүрийг ургийн хөгжлийн эрт илрүүлэгт хамруулах үүднээс Орхон аймагт пренаталогийн төв байгуулах зэрэг хэрэгцээ, шаардлагууд тулгарч байна.

Эмэгтэйчүүд, эрэгтэйчүүд: Орхон аймгийн нийт хүн амын 51.1 хувийг эмэгтэйчүүд, 48.9 хувийг эрэгтэйчүүд эзэлж байна. Өрх толгойлсон эхийн тоо 1.1 мянга, өрх толгойлсон эцэг 196 байгаа нь 2020 онтой харьцуулахад эхийн тоо 8.5 хувиар буурсан бол ганц бие эцгийн тоо 41.0 хувиар өссөн.

Хөдөлмөрийн насны хүн амын 69.5 хувь нь эрэгтэй ажиллах хүч, ажиллагчдын 55.3 хувь нь эрэгтэй бол, бүртгэлтэй ажилгүйчүүдийн 59.1 хувь нь эмэгтэй байгаа юм. 2020 онтой харьцуулахад ажиллах хүчний оролцооны түвшин 9.9, хөдөлмөр эрхлэлтийн түвшин 9.7 пунктээр буурсан. Ажилгүйдлийн түвшин эрэгтэй хүн амд 10.0 буюу эмэгтэй хүн амаас 4.5 пунктээр илүү байна. Их дээд

сургууль, коллежид суралцагчдын 58.7 хувь нь эмэгтэйчүүд бол, мэргэжлийн боловсрол эзэмшигчдийн 60.5 хувь нь эрэгтэйчүүд байна.

Нийт 5,007 төрийн албан хаагчдын 74.3 хувь нь эмэгтэй, үүнээс төрийн үйлчилгээний албан хаагч эмэгтэйчүүд 3,302 буюу 65.9 хувийг эзэлж байна. Нийгмийн халамж, даатгалын үйлчилгээнд эмэгтэйчүүдийн 78.6 хувь нь хамрагджээ.

Гэмт хэрэгт холбогдсон яллагдагчдын 85.2 хувь нь эрэгтэйчүүд байгаа хэдий ч, эмэгтэйчүүдийн өмнөх онтой харьцуулахад гэмт хэрэгт холбогдох нь 8.4 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас 315 хүн хохирсны 222 буюу 70.4 хувь нь эмэгтэйчүүд (эхнэр) байна.

Эрт илрүүлэг, урьдчилан сэргийлэх үзлэгт нийт 56.9 мянган хүн хамрагдсаны 56.7 хувь нь эмэгтэй, 43.2 хувь нь эрэгтэй бол нийт нас баралтын 62.1 хувь нь эрэгтэйчүүд байна. Нас баралтын 35.4 хувийг зүрх судас, 31.2 хувийг хорт хавдар, 6.5 хувийг осол гэмтэл, гаднын шалтгаант нас баралт эзэлж байна. Дундаж наслалт 2020 онтой харьцуулахад 73.34 болж өссөн хэдий ч, эрэгтэй хүн амын дундаж наслалт эмэгтэй хүн амаас 11.6 насаар зөрүүтэй байгаа юм. 2024 онд шинээр бүртгэгдсэн хавдар өвчний 57.7 хувьд нь эрэгтэйчүүд бүртгэгдсэн.

Эрэгтэйчүүдийн эрүүл мэнддээ тавих анхаарал, амьдралын хэв маяг зэрэг нь тэдний дундаж наслалтад нөлөө үзүүлэхүйц асуудал болоод байна. Бүсийн оношилгоо, эмчилгээний төвийн эрчүүдийн кабинетын тоног төхөөрөмжийн хангалт 88.0 хувь байгааг нэмэгдүүлж хөрөнгө оруулалт хийх, эмэгтэйчүүдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж, шийдвэр гаргах түвшинд оролцоог нь нэмэгдүүлэх, гэр бүлийн болон нийгмийн орчинд аюулгүй байдлыг хангах талаар тодорхой ажлууд зохион байгуулах шаардлагатай байна.

Залуучууд: Нийт хүн амын 56.9 хувийг 16-59 насны хөдөлмөрийн насны хүн ам эзэлж байна. Аймгийн хэмжээнд 16-34 насны 26.3 мянган залуучууд байгаа нь хөдөлмөрийн насны хүн амын 43.6 хувийг, энэ насны бүлгийн ажиллах хүчний 39.1 хувийг, ажиллагчдын 41.1 хувийг, ажилгүй байгаа хүн амын 53.3 хувийг, нийт төрсөн эхчүүдийн 77.5 хувийг, гэрлэлтээ бүртгүүлсэн иргэдийн 95.4 хувийг, төрийн албан хаагчдын 29.5 хувийг тус тус эзэлж байна. Ажилгүйдлийн түвшин 20-24 насны бүлэгт хамгийн өндөр буюу 25.9 хувь байна.

Нийт гэмт хэрэг үйлдэгчдийн 59.4 хувийг залуучууд эзэлж байгаа нь өмнөх оноос 20.4 хувиар өссөн ба гэмт хэргийн улмаас хохирогчдын 37.0 хувийг залуучууд эзэлж байна.

Эрт илрүүлэг, үзлэгт хамрагдсан 18-30 насны залуучуудын сэжигтэй тохиолдлын 70.0 хувьд нь зүрх судасны тогтолцооны өвчин бүртгэгдсэн нь өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байна. Ээлжит цэрэг татлагын үеэр залуучуудын талаас илүү хувь нь эрүүл мэндийн үзлэгт тэнцэхгүй байгаа нь анхаарах асуудлын нэг болж байна.

Залуучуудад хөдөлмөрийн зах зээлд шаардлагатай мэргэжил боловсрол эзэмшихэд дэмжлэг үзүүлэх, тэдэнд эрүүл зөв амьдралын хэв маягийг хэвшүүлэх, эрсдэл болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, нийгмийн амьдралд оролцох идэвх оролцоог нэмэгдүүлэх чиглэлээр нөлөөллийн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулах шаардлагатай байна.

Ахмад настан: Аймгийн нийт хүн амын 10.2 хувийг 60 ба түүнээс дээш насны ахмадууд эзэлж, 2020 онтой харьцуулахад 31.3 хувиар өссөн. Өрх үүсгэн

ганц биеэр амьдардаг 55 ба түүнээс дээш насны 1,140 эмэгтэй, 60 ба түүнээс дээш насны 449 эрэгтэй байгаа нь 2020 онтой харьцуулахад эмэгтэй 15.4 хувиар, эрэгтэй 23.8 хувиар өссөн.

Нийт ажиллах хүчний 4.1 хувь, ажиллагчдын 8.9 хувь, төрийн албан хаагчдын 7.6 хувь нь 55 ба түүнээс дээш насны ахмад настан, нийгмийн даатгалын сангаас өндөр насны тэтгэвэр авагч 14.9 мянга, нийгмийн халамжийн сангаас өндөр насны тэтгэвэр авагч 236 ахмад бүртгэгдсэн ба нийгмийн халамж, даатгалын үйлчилгээнд ахмад настны 97.2 хувь нь хамрагджээ.

Нас барсан нийт хүний 56.0 хувийг ахмадууд эзэлж, ахмадын өвчлөлийг шалтгаанаар авч үзвэл зүрх судасны эмгэг 55.5 хувь, хоол боловсруулах замын эмгэг 14.5 хувийг эзэлж өвчлөлийн тэргүүлэх шалтгаан болж байна.

Ахмадуудын тэтгэвэр тэтгэмж нь амьжиргаанд нь хүрэлцэхгүй байх, тэргүүлэх шалтгаан болж буй өвчлөл нь тэдний амьдралын чанарт нөлөөлж, нийгмийн оролцоог нь бууруулж байна. Мөн ганц бие ахмадууд ганцаардлаас үүдэлтэй сэтгэл зүйн хямралд орж, нийгмийн дэмжлэг авч чадахгүй байх нь түгээмэл байгаа тул эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгааллын дэмжлэг туслалцааг өргөжүүлэх шаардлагатай байна.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэд: Орхон аймагт нийт 4,582 хөгжлийн бэрхшээлтэй иргэд байгаа нь нийт хүн амын 4.3 хувийг эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн 27.0 хувь нь төрөлхийн, 73.0 хувь нь олдмол шалтгаантай бол 45.1 хувь нь эмэгтэйчүүд байна. Өвчнөөр хөгжлийн бэрхшээлтэй болсон 2,669 хүний 87.6 хувь нь ердийн өвчнөөр, 12.4 хувь нь мэргэжлээс шалтгаалах өвчнөөр хөгжлийн бэрхшээлтэй болсон. Осол гэмтлийн шалтгаантай хөгжлийн бэрхшээлтэй болсон 582 хүний 33.8 хувийг зам тээврийн, 18.5 хувийг үйлдвэрлэлийн осол, 47.5 хувийг ахуйн осол тус тус эзэлж байна. Хөгжлийн бэрхшээлийг хэлбэрээр нь авч үзвэл хараа 9.1 хувь, сэтгэц 17.0 хувь, хэл яриа 1.8 хувь, хавсарсан 8.2 хувь, сонсгол 8.3 хувь, бусад 34.5 хувь, хөдөлгөөний бэрхшээл 20.6 хувийг эзэлж байна.

Хөгжлийн бэрхшээлтэй хүний 10.8 хувь нь 0-18 насны, 17.3 хувь нь 19-34 насны залуучууд, 64.5 хувь нь 35-64 насны хүн ам, 7.5 хувь нь 65 ба түүнээс дээш насны ахмад байна. Байнгын асаргаанд байдаг 1,729 иргэн бүртгэгдсэн нийт хөгжлийн бэрхшээлтэй хүний 37.7 хувийг эзэлж байна. Хөдөлмөр эрхэлдэг 542, огт сургуульд сурдаггүй 71 хүүхэд бүртгэгдсэн.

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн орчинд саадгүй бүрэн дүүрэн оролцоход нь барилга байгууламж, зам талбай, нийтийн тээврийн үйлчилгээ зэрэг нь стандартын шаардлага бүрэн хангахгүй байна. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг боловсролд тэгш хамруулах чиглэлээр ажлууд хийгдэж байгаа ч боловсролын байгууллагуудад тохируулгатай сургалтын орчин, мэргэжлийн багшлах боловсон хүчин дутагдалтай, хөдөлмөр эрхлэх боломжийн хувьд ажил олгогчид хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг ажилд авахдаа тэдний чадавх, хэрэгцээ шаардлагад нийцсэн тохируулгатай ажлын байр бэлтгэх тал дээр дутмаг байна. Ажил олгогчдод зориулсан сургалт, дэмжлэгийг үзүүлэх, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн нийгмийн оролцоог нэмэгдүүлэх, эмнэлгийн тусламж, асаргаа, сувилгаа, сэргээн засах үйлчилгээний чанар, хүртээмжийг илүү сайжруулах зэрэг хэрэгцээ шаардлага тулгарч байна.

2.2.НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦ:

Боловсрол: Аймгийн хэмжээнд хүүхдийн цэцэрлэгт 410 бүлгийн багш, 309 туслах багш, 74 удирдах ажилтан, ерөнхий боловсролын сургуульд 1,288 багш, 116 удирдах ажилтан ажиллаж, хүүхдийн цэцэрлэг болон ерөнхий боловсролын сургуульд нийт 2,197 багш, удирдах ажилтан ажиллаж байна.

Эдгээр багш, ажилтнуудын хөгжлийг дэмжих, нийгмийн баталгааг хангах чиглэлээр орон нутгийн хэмжээнд 2021-2024 онд “Багш” хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлсэн бөгөөд хөтөлбөрийн хүрээнд багш нарыг судалгаа шинжилгээний ажил хийх арга зүйд суралцуулах, анги удирдсан багшийг мэргэшүүлэх, хөгжүүлэх, багш, ажилтны ёс зүй, харилцаа хандлагыг дээшлүүлэх, математик, монгол хэлний хичээлийн сургалтыг сайжруулах, элсэлтийн ерөнхий шалгалт, анги нийтийн сургалтын чанарыг дээшлүүлэх зэрэг арга хэмжээг тусган хэрэгжүүлсэн.

Хөтөлбөрийн хүрээнд явагдсан ЭЕШ-ын чанарыг дээшлүүлэх олон талт арга хэмжээний үр дүнд хэмжээст онооны аймгийн дундаж 2020 онд 507 байсан бол 2023 онд 540.8, багш, ажилтнуудад чиглэсэн төрөл бүрийн сургалт үйл ажиллагааны үр дүнд сургууль, цэцэрлэгүүдийн гүйцэтгэлийн үнэлгээний хувь дээшилж, багшийн гүйцэтгэлийн үнэлгээгээр 1-4 дүгээр түвшинд үнэлэгдэж урамшуулал авч буй ЕБС, СӨББ-ын багшийн тоо 2022 онд 536 байсан бол 2024 онд 639, байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээнд хамрагдсан төрийн өмчийн цэцэрлэгүүдийн дундаж үнэлгээ 2022 онд 88.02 хувь байсан бол 2024 онд 88.9 хувь, ЕБС-иудын үнэлгээ 2022 онд 74.3 хувь байсан бол 2024 онд 75.9 хувь, сургалтын чанарын үзүүлэлт 2020 онд 80.5 хувь байсан бол 2024 онд 85.4% хувь болж тус тус өссөн байна.

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Засгийн газрын 2024 оны 192 дугаар тогтоолоор батлагдсан “Багшийн 3 тулгуурт хөгжлийн бодлого” зэрэг эрх зүйн баримт бичгүүдтэй уялдуулж, энэ хөтөлбөрөөр үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Соёл: Соёл урлаг, аялал жуулчлал, залуучуудын газар, Хүүхэд залуучуудын театр, Музей, Нийтийн номын сан, “Аялгуу”, “Баянцагаан”, “Хэмнэл”, “Баян-Өндөр”, “Эгшиглэн”, “Жаргалант” соёл мэдээллийн төв, “Эрдэнэт үйлдвэр” ТӨҮГ-ын дэргэдэх Соёл, урлагийн цогцолбор зэрэг нийт 11 байгууллагад нийт 222 албан хаагч ажиллаж байна. Албан хаагчдыг боловсролын түвшнээр нь авч үзвэл магистрын зэрэгтэй 16, бакалаврын зэрэгтэй 137, техникийн болон мэргэжлийн боловсролтой 31, бүрэн дунд боловсролтой 34, суурь боловсролтой 4 албан хаагчаас соёлын салбарын хүний нөөц бүрдэж байгаа бөгөөд эмэгтэй 132, эрэгтэй 90, насны бүтцээр нь авч үзвэл 22 хувь нь 25-34 нас, 42.3 хувь нь 35-44 нас, 29.7 хувь нь 45-54 нас, 5.8 хувь нь 55 ба түүнээс дээш насны албан хаагчид байна.

Соёлын тухай хуулийн 24.1.2-т зааснаар аймгийн Засаг дарга “Орон нутгийн өмчийн соёлын байгууллагын хүний нөөцийг хөгжүүлэх, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах” үүргийг хүлээсэн байдаг. Хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс соёл, урлагийн салбарыг хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр өнгөрсөн жилүүдэд “Соёл, урлагийн байгууллагуудыг мэргэжлийн боловсон хүчнээр хангах, мэргэжил дээшлүүлэх сургалтад үе шаттай хамруулах ажлыг зохион байгуулах” заалтыг аймгийн Засаг даргын үйл

ажиллагааны хөтөлбөрт тусган, албан хаагчдыг мэргэжлийн болон бусад сургалтуудад хамруулахад жил бүр дэмжлэг үзүүлж ирсэн. Мөн соёлын байгууллагууд албан хаагчдаа чадавхжуулах ажлыг үндсэн үйл ажиллагааныхаа хүрээнд тодорхой хэмжээнд хийж ирсэн хэдий ч аймгийн хэмжээнд мэргэжлийн найруулагч, дуу шум, дүрсний инженер, хормейстер, концертмейстер, балетмейстер зэрэг соёлын нарийн мэргэжил дутагдалтай байсаар байна.

Эрүүл мэнд: Аймгийн хэмжээнд төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн 161 байгууллагад 2,089 эрүүл мэндийн ажилтан эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэн ажиллаж байгаагаас 22.7 хувийг эмч, 24.5 хувийг сувилагч, тусгай дунд мэргэжилтэн эзэлж байна. Үүний 10.5 хувь нь анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлдэг өрх, сумын эрүүл мэндийн төвүүдэд, 25.1 хувь нь Бүсийн оношилгоо эмчилгээний төвд, 27.2 хувь нь хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад, 5.3 хувь нь Эрдэнэт сувиллын цогцолборт, 21.1 хувь нь эм ханган нийлүүлэх, эмийн сан, шүдний эмнэлэг, ариутгал халдваргүйтгэл зэрэг бусад байгууллагад ажиллаж байна.

10,000 хүн амд ноогдох их эмчийн тоо 45, сувилагч, тусгай дунд мэргэжилтний тоо 48.6 байгаа нь улс, аймгийн дунджаас өндөр байгаа ч эмч сувилагчийн харьцаа 1:1.1 байна. Эрүүл мэндийн салбарын эмч, эмнэлгийн мэргэжилтнүүдийг сургах, тэдгээрийн нийгмийн баталгааг хангах зорилготой “Эмч” хөтөлбөр өнгөрсөн жилүүдэд 2 үе шаттайгаар 98.6 хувийн гүйцэтгэлтэй, 58 шинэ төрлийн эмчилгээ үйлчилгээ нэвтрүүлж, үр дүнтэй хэрэгжүүлсэн.

2025-2028 онд эрүүл мэндийн салбарт Хавдрын оношилгоо, эмчилгээ, хяналт сэргийлэлтийн төв, Пренаталог оношилгооны төв, Харвалт, шигдээсний төв (Зүрхний хэм алдалт), Яаралтай тусламжийн төв тус тус байгуулагдах тул энэхүү хөтөлбөрөөр эмч хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр төлөвлөсөн.

Спорт: Аймгийн хэмжээнд биеийн тамир, спортын төрийн болон төрийн бус байгууллагад 417 албан хаагч ажиллаж байна. Үүнээс 236 биеийн тамирын багш дасгалжуулагч, улсын шүүгч (волейбол, самбо) 2, олон улсын шүүгч (мас-рестлинг, жүдо) 2, зэрэглэлтэй дасгалжуулагч 11 байна. Спортын салбарт бодлого боловсруулах албан хаагчдын орон тоог нэмж, спортын холбоодод дасгалжуулагч, шүүгчдийг мэргэшүүлэх, зэрэг олгох сургалтуудыг зохион байгуулдаг ч спортын төрлүүдийн зэрэглэлтэй шүүгч, дасгалжуулагчдыг нэмж бэлтгэх, өсвөрийн шигшээ багийн тамирчдын амжилтыг тогтворжуулах, ахиулах, мэргэжлийн баг ажиллуулахад хүний нөөц дутагдалтай байна.

Хөдөлмөр, нийгмийн хамгаалал: Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгааллын газар нь нийт 54 орон тоотой ажиллаж байгаагаас төрийн захиргааны 9, төрийн үйлчилгээний 45 албан хаагчтай. Хүний нөөцийн хувьд нийт албан хаагчдын 90 хувь нь бакалавр, магистрын боловсролтой, 72 хувь нь нийгмийн хамгаалал, эрх зүй, социологи, багш мэргэжилтэй албан хаагчид байна.

Нийгмийн даатгалын газар нь нийт 50 албан хаагчтай ба үүнээс төрийн захиргааны 32, төрийн үйлчилгээний 8, нийгмийн даатгалын 10 төлөөлөгч тус тус ажиллаж албан хаагчдын 51.3 хувийг 35-44 насныхан, 42 хувийг эдийн засгийн боловсролтой албан хаагчид эзэлж байна.

Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний газар нь нийт 50 орон тоотой ажиллаж байгаагаас төрийн жинхэнэ албан тушаалд 38, төрийн үйлчилгээний албан тушаалд 12 ажилтан ажиллаж байна. Нийгмийн хамгаалал, санхүүгийн чиглэлийн

албан хаагчид 17 буюу 34.0 хувь, бусад мэргэжлийн албан хаагчид 26.0 хувийг эзэлж байна. Мөн тус газрын дэргэд Ахмадын амралт, сувилал 8 орон тоотой үйл ажиллагаа явуулдаг.

Аймгийн боловсрол, эрүүл мэнд, соёл, урлаг, спорт, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын нийт 240 гаруй байгууллагад 4,837 ажилтан, албан хаагч ажиллаж байгаа нь аймгийн нийт төрийн албан хаагчдын 96.6 хувийг эзэлж, салбарын үйлчилгээг иргэдэд хүргэж байна. Үүнээс эрүүл мэндийн салбарт 2,089, боловсролын салбарт 2,197 албан хаагч ажиллаж байгаа нь салбарын нийт албан хаагчдын 88.0 хувийг эзэлж байгаа юм. Боловсрол, эрүүл мэндийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх чиглэлээр өнгөрсөн хугацаанд орон нутгийн хэмжээнд “Багш”, “Эмч” хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж багш болон эмч, эмнэлгийн ажилтнуудыг чадавхжуулах, мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх үйл ажиллагааг зохион байгуулж, тодорхой үр дүнд хүрсэн ч бусад салбарууд болох соёл урлаг, спорт, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарт ажиллаж буй албан хаагчдыг чадавхжуулах, хөгжүүлэх чиглэлээр нэгдсэн бодлого, зохицуулалт байхгүй байна.

Иймээс нийгмийн салбарт шаардлагатай хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сургах, хөгжүүлэх асуудлыг цогцоор нь авч үзэх, энэ чиглэлийн үйл ажиллагааны үр дүнг нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид гарч буй ахиц, өөрчлөлтөөр нь хэмжихэд чиглэсэн нэгдсэн бодлого, төлөвлөлтийг боловсруулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

ГУРАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛГО

Нийгмийн салбарт шаардлагатай хүний нөөцийг төлөвлөх, бүрдүүлэх, сургах, хөгжүүлэх, үнэлэх, шагнаж урамшуулах, тогтвор суурьшилтай ажиллуулахад чиглэсэн хүний нөөцийн менежментийн үндсэн чиг үүргийг хэрэгжүүлэх замаар хүүхэд (гэр бүл), эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд), залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын бүлгүүдэд хүргэх нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулж, иргэдийн оролцоо, хүлээсэн үүргийн ёс зүйд тулгуурлана.

ДӨРӨВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУД

- 4.1.Хүн амын бүлгүүдийн хөгжлийг хангах
- 4.2.Нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийг хангах

ТАВ.ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТУУДЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГАА, АРГА ХЭМЖЭЭ

5.1. Хүүхэд (гэр бүл), эмэгтэйчүүд (эрэгтэйчүүд), залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд зэрэг хүн амын бүлгүүдийн хөгжлийг хангах нэгдүгээр зорилтын хүрээнд:

5.1.1.Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулахад гэр бүлд суурилсан үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлийн гишүүдийн бие бялдрын хөгжилд анхаарах, эрүүл, зөв амьдралын хэв маяг, эерэг хандлагыг төлөвшүүлж, гэр бүл болон нийгмийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангана.

5.1.2.Эрэгтэйчүүд, эмэгтэйчүүдийн тулгамдсан асуудлыг тэдний онцлог, хэрэгцээнд нийцүүлж хамтын оролцоотойгоор шийдвэрлэн, бүх төрлийн донтолт

болон аливаа эрсдэлт хүчин зүйлээс сэргийлж, нөхөн сэргээх, эдийн засгийн чадавхыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, нийгмийн тэгш байдлыг бий болгоно.

5.1.3.Залуучуудын сурч боловсрох, хөгжих, манлайлах санаачилгыг дэмжиж, амьдралын зөв дадал, хэв маягийг хэвшүүлж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.

5.1.4.Ахмад настанд үзүүлэх эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгааллын дэмжлэг тусламж, үйлчилгээг өргөжүүлж, ахмадын нийгмийн идэвх санаачилга, зөвлөн туслах үйлчилгээг дэмжин, хөдөлмөр эрхлэх хувилбарт боломжуудыг бүрдүүлж, амьдралын чанарыг сайжруулна.

5.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан амьдрахад шаардлагатай хүртээмжтэй, тохируулгатай орчныг бүрдүүлж, бие махбодын болон сэтгэл зүйн сэргээн засах тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, тэдний хөгжил, оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.

5.2.Боловсрол, эрүүл, мэнд, спорт, соёл урлаг, хөдөлмөр, нийгмийн хамгаалал зэрэг нийгмийн салбарын хүний нөөцийг хөгжүүлэх хоёрдугаар зорилтын хүрээнд:

5.2.1.Нийгмийн салбарын хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг сайжруулж, хүний нөөцийн төлөвлөлт, бүрдүүлэлтийг оновчтой болгоно.

5.2.2.Нийгмийн салбарын гадаад, дотоод хамтын ажиллагааг өргөжүүлж, хүний нөөцийн сургалт, хөгжлийг бодит хэрэгцээнд тулгуурлан дэмжиж, албан хаагчдын ажлын гүйцэтгэл, бүтээмжийг дээшлүүлж, судлаач албан хаагчдыг бэлтгэнэ.

5.2.3.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамжийг дээшлүүлж, албан хаагчдын амжилтыг үнэлж, урамшуулна.

5.2.4.Нийгмийн салбарын байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоог нэвтрүүлнэ.

ЗУРГАА.ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮН

6.1.Эрүүл мэнд, боловсрол, соёл, спорт, хөдөлмөр нийгмийн хамгаалал зэрэг нийгмийн салбарын үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдэж, хүн амын бүлгүүдийн амьдралын чанар сайжирна.

6.1.1.Хүүхдийн эрүүл мэндийн байдал, бие бялдар, оюун санааг хөгжүүлэх, хамгаалах зэрэгт эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо нэмэгдэж, эрсдэлт хүчин зүйл буурна.

6.1.2.Эрэгтэйчүүдийн эрт илрүүлгийн хамрагдалт нэмэгдэж, хүйсийн дундаж наслалтын зөрүүг багасаж, донтох эмгэг буурч, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн чадавх дээшилнэ.

6.1.3.Залуучуудын нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, эрүүл мэндийн боловсрол дээшилж, өвчлөл буурна.

6.1.4.Ахмадуудад чиглэсэн үйл ажиллагаа өргөжиж, эрүүл мэндийн болон нийгмийн дэмжлэг тусламжаа нэмэгдэж, амьдралын чанарт ахиц гарна.

6.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах боломж, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар сайжирч, нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.

6.2.Нийгмийн салбарын хүний нөөцийн менежментийн тогтолцоо боловсронгуй болж, мэдлэг, мэргэшил, ур чадвар, бүтээмж, сэтгэл

ханамж бүхий хүний нөөц бүрдэж, нийгмийн үйлчилгээний чанар хүртээмж нэмэгдсэн байна.

6.2.1.Нийгмийн салбар тус бүрд хүний нөөцийг удирдан чиглүүлэх бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байна.

6.2.2.Нийгмийн салбарын хүний нөөцийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ тодорхойлогдож, чадварлаг албан хаагчдаар хүний нөөцийн бүрдүүлэлт хийгдсэн байна.

6.2.3.Нийгмийн салбарын албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэл дээшилж, нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.

6.2.4.Нийгмийн салбарын хүний нөөцийн сэтгэл ханамж дээшилж, ажлын байранд сэтгэл зүйн таатай орчин бүрдсэн байна.

6.2.5.Нийгмийн салбарын байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байна.

ДОЛОО.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХЭД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

7.1.Үйл ажиллагааны ил тод, тэгш байдлыг хангах

7.2.Төрийн бодлогын залгамж чанарыг хадгалсан байх

7.3.Иргэд, олон нийт, албан хаагчдын эрэлт хэрэгцээнд тулгуурласан, эрх ашигт нийцсэн, оролцоог хангасан байх

7.4.Оролцогч бүх талын дэмжлэгт түшиглэх

НАЙМ.ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

8.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр салбарын байгууллагуудын бодлого, төлөвлөлтөд тусган, уялдаа холбоог сайжруулж, хэрэгжилтийг хангахад төр, иргэний нийгмийн хамтын ажиллагааг идэвхжүүлж ажиллана.

8.2.НҮБ, бусад олон улсын болон хувийн хэвшил, аж ахуйн нэгж байгууллагын дэмжлэг, санал санаачилга, хөрөнгө оруулалтыг дэмжиж хамтран ажиллана.

8.3.Хүн амын бүлэг, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжилд иргэдийн оролцоог өргөжүүлэх чиглэлээр иргэний нийгэм, хэвлэл мэдээллийн байгууллагуудаас гаргаж буй санал, санаачилгыг дэмжинэ.

8.4.Хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулах ажлыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс, түүний харьяа нийгмийн салбарын байгууллагууд, бусад төрийн болон иргэний нийгмийн байгууллага, хувийн хэвшлийн байгууллагууд хамтран хэрэгжүүлнэ.

8.5.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аймгийн Засаг даргаар батлуулж, хэрэгжилтийг жил бүрийн I улиралд багтаан аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнана.

ЕС.ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИХ ХУГАЦАА

Хүн амын бүлгүүд, нийгмийн салбарын хүний нөөцийн хөгжлийн хөтөлбөрийг 2025-2028 он хүртэл дунд хугацаанд хэрэгжүүлнэ.

АРАВ.ХӨТӨЛБӨРИЙН САНХҮҮЖИЛТ

10.1.Хөтөлбөрийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг дараах эх үүсвэрээс санхүүжүүлнэ:

10.1.1.улс, орон нутгийн төсөв;

10.1.2.гадаадын зээл, тусламж, хөрөнгө оруулалт;

10.1.3.хувийн хэвшил, аж ахуйн нэгжийн хөрөнгө оруулалт;

10.1.4.бусад эх үүсвэр.

10.2.Хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд тухайн салбарын асуудлыг эрхэлсэн байгууллага шаардагдах хөрөнгийг жил бүрийн улсын болон орон нутгийн төсөвт тусган хэрэгжүүлнэ.

АРВАН НЭГ.ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТ, ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ

11.1.Хөтөлбөрийн хэрэгжилтэд хийх хяналт шинжилгээ, үнэлгээг Засгийн газраас баталсан нийтлэг журмын дагуу хийнэ.

11.2.Хяналт шинжилгээ, үнэлгээний үр дүн, дүгнэлттэй уялдуулан төлөвлөлтөд нэмэлт, өөрчлөлт оруулах замаар тулгамдсан асуудлыг шийдвэрлэх арга хэмжээг авна.

**АРВАН ХОЁР. ХӨТӨЛБӨРИЙН ҮР ДҮНГИЙН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ,
ЗОРИЛТОТ ТҮВШИН**

№	Хөтөлбөрт тусгагдсан үндсэн үйл ажиллагаа	Үр дүн	Шалгуур үзүүлэлт (Тухайн жилд)	Хэмжих нэгж	Суурь түвшин		Зорилтот түвшин				Мэдээллийн үзүүлэлтүүд		
					Он	Түвшин	2025 он	2026 он	2027 он	2028 он	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1. ХҮН АМЫН БҮЛГҮҮДИЙН ХӨГЖИЛ													
1	5.1.1. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулахад гэр бүлд суурилсан үйл ажиллагааг өргөжүүлж, гэр бүлийн гишүүдийн бие бялдрын хөгжилд анхаарах, эрүүл, зөв амьдралын хэв маяг, эерэг хандлагыг төлөвшүүлж, гэр бүл болон нийгмийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангана.	Хүүхдийн эрүүл мэндийн байдал, бие бялдар, оюун санааг хөгжүүлэх, хамгаалах зэрэгт эцэг эх, асран хамгаалагчийн үүрэг оролцоо нэмэгдэж, эрсдэлт хүчин зүйл буурна.	ЕБС, СӨББ болон бусад байгууллагын хүүхэд хамгааллын бодлогын хэрэгжилтийн хувь	Хувь	2024	85.0%	87.0%	89.0%	91.0%	93.0%	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
2	Гишүүдийн бие бялдрын хөгжилд анхаарах, эрүүл, зөв амьдралын хэв маяг, эерэг хандлагыг төлөвшүүлж, гэр бүл болон нийгмийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангана.	Хүүхдийн хөгжил, оролцоо нэмэгдүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүүхэд	Хүүхдийн хөгжил, оролцоо нэмэгдүүлэх арга хэмжээнд хамрагдсан хүүхэд	Тоо	2024	5,000	8,000	9,000	10,000	11,000	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
3	Төлөвшүүлж, гэр бүл болон нийгмийн орчинд хүүхдийн аюулгүй байдлыг хангана.	Хүүхдийн хөгжил, оролцоо нэмэгдэж, эрсдэлт хүчин зүйл буурна.	"Нэг анги-Нэг өглөө" арга хэмжээнд эцэг эх, хүүхдийн хамрагдалт	Тоо	2024	15,000	15,500	16,000	16,500	17,000	БТСГ-ын тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
4			"Гэр бүлийн цогц төв" байгуулагдсан эсэх	Тоо	2024	-	1 төв	-	-	-	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
5			Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийн илрүүлэлт	Тоо	2024	607	807	1,007	1,207	1,407	ХГБХХГ-ын тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
6			Товлолын дархлаажуулалт ад хамрагдалт	Хувь	2024	99.0%	99.3%	99.4%	99.5%	99.6%	ЭМГ-ын статистик мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
7			Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдсэн гэмт хэргийн бууралт	Тоо	2024	66	60	55	50	40	ЦГ-ын статистик мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
8			Тур хамгаалах байрны барилгын ажлын гүйцэтгэл	Хувь	2024	79%	-	100%	-	-	АЗДТГ, ХГБХХГ, ЦГ-ын тайлан, мэдээлэл	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
9			Бие бялдрын түвшин тогтоох сорилд хамрагдагчдаас хэвийн үзүүлэлттэй иргэдийн эзлэх жин	Хувь	2024	54.1%	55.0%	57.0%	59.0%	62.0%	БТСГ, БГ-ын тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
10	5.1.2.Эрэгтэй-чүүд, эмэгтэй-чүүдийн тулгамдсан асуудлыг тэдний онцлог, хэрэгцээнд нийцүүлж, хамтын оролцоотой-	Эрэгтэй-чүүдийн эрт илрүүлгийн хамрагдалт	Эрэгтэйчүүдийн үзлэгт хамрагдалтын хувь	Хувь	2024	43.6%	44.7%	44.7%	45.9%	46.2%	ЭМГ-ын статистик мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
11			Хүйсийн дундаж наслалтын зөрүү	Жил-лээр	2023	11.62	-	-	-	10.95	ЭМГ-ын статистик мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
12	гоор шийдвэрлэж, бүх төрлийн донтолт болон аливаа эрсдэлт хүчин зүйлээс сэргийлж, нөхөн сэргээх, эдийн засгийн чадаахыг дээшлүүлэх нөхцөлийг бүрдүүлэн, нийгмийн тэгш байдлыг бий болгоно.	нэмэгдэж, хүйсийн дундаж наслалтын зөрүү багасгаж, донтох эмгэг буурч, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн чадавч дээшилнэ	Эмэгтэйчүүдийн хөдөлмөрийн эрхлэлт	Хувь	2023	20%	20.4	20.6	20.8	21.0	ХХҮГ Статистикийн хэлтсийн мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
13			Сургалт, нөлөөллийн үйл ажиллагаанд хамрагдсан иргэд	Хувь	2024	15.2%	15.0%	15.1%	15.2%	15.3%	Насан туршийн суралца-хуйн төвийн тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
14			Сэтгэц нийгмийн сэргээн засах төв байгуулагдсан эсэх	Тоо	2024	1	-	-	1	-	АЗДТГ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
15	5.1.3.Залуучуудын сурч боловсрох, хөгжих, манлайлах санаачилгыг дэмжиж, амьдралын зөв дадал, хэв маягийг хэвшүүлж, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлнэ.	Залуучуудын нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэж, эрүүл мэндийн боловсрол дээшилж, өвчлөл буурна.	Сургалт, нөлөөллийн арга хэмжээнд хамрагдсан залуучууд	Тоо	2024	18,000	20,000	22,000	24,000	26,000	СУАЖЗГ-ын статистик мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
16			Залуучуудын хөдөлмөрийн эрхлэлт	Хувь	2023	46.7%	46.9%	47.0%	47.2%	47.5%	ХХҮГ Статистик мэдээлэл	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
16			Залуучуудын эрт илрүүлэгт хамрагдалт	Хувь	2024	17.4%	18.5%	19.6%	20.7%	22.1%	ЭМГ-ын статистик мэдээлэл	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
17			Нийт гэмт хэрэг үйлдсэн хүн амд залуучуудын эзлэх жин	Хувь	2024	59.4	58.0	57.0	55.0	53.0	ЦГ-ын статистик мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
19			Зурх судасны өвчлөлөөс шалтгаалсан нас баралтын түвшин (10,000 хүн амд)	Түвшин	2024	19.9	19.0	18.5	17.0	16.5	ЭМГ-ын статистик мэдээлэл	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
20	5.1.4.Ахмад настанд үзүүлэх эрүүл мэнд, сэтгэл зүй, нийгмийн хамгааллын дэмжлэг тусламж, үйлчилгээг өргөжүүлж, ахмадын нийгмийн идэвх санаачилга, зөвлөн туслах үйлчилгээг дэмжин, хөдөлмөр эрхлэх хувилбарт боломжуудыг	Ахмадад чиглэсэн үйл ажиллагаа өргөжиж, эрүүл мэндийн болон нийгмийн дэмжлэг тусалцаа нэмэгдэж, амьдралын чанарт ахиц гарна.	Ахмадууд болон анхдагчдад чиглэсэн олон талт арга хэмжээнд хамрагдсан ахмад	Тоо	2024	14,000	14,500	15,000	15,500	16,000	Ахмадын хорооны тайлан, мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
21			Асаргаа сувилгааны цогц төв байгуулсан эсэх	Тоо	2024	-	1	-	-	-	ХХУГ мэдээлэл	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
22	бүрдүүлж, амьдралын чанарыг сайжруулна.		Ахмад настны хөдөлмөр эрхлэлт	Хувь	2023	16.4	16.6	16.8	17.0	17.2	Статистикийн хэлтэс, ХХҮГ-ын мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
23	5.1.5.Хөгжлийн бэрхшээлтэй иргэд бие даан амьдрахад шаардлагатай хүртээмжтэй, тохируулгатай орчныг бүрдүүлж, бие махбодын болон сэтгэл зүйн сэргээн засах тусламж үйлчилгээний чанар сайжирч, нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн бие даан амьдрах боломж, сэргээн засах тусламж үйлчилгээний чанар сайжирч, нийгмийн оролцоо, хөдөлмөр эрхлэлт нэмэгдэнэ.	Сэргээн засах тусламж үйлчилгээнд хамрагдсан хөгжлийн бэрхшээлтэй иргэд	Тоо	2024	2101	2300	2700	3000	3200	ЭМГ-ын статистик мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
24	орчныг бүрдүүлж, бие махбодын болон сэтгэл зүйн сэргээн засах тусламж үйлчилгээг нэмэгдүүлэн, тэдний хөгжил, оролцоо, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хөдөлмөр эрхлэлт	Хувь	2023	18.2%	18.4%	18.6%	18.8%	19.0%	ХХҮГ, Статистикийн хэлтсийн мэдээ	Тоон үзүүлэлтүүдэд тулгуурлах	Жилд 1 удаа
25			Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хэрэгцээнд нийцсэн дэд бүтэц, барилга байгууламжийн стандартын хэрэгжилт	хувь	2024	25.0%	26.0%	28.0%	29.0%	30.0%	ЗДТГ,ХХУ Г, ХЗА, СХЗГ нэгдсэн үзлэг	Үзлэгийн дүн, мэдээлэлд тулгуурлах	Жилд 1 удаа

2. НИЙГМИЙН САЛБАРЫН ХҮНИЙ НӨӨЦИЙН ХӨГЖИЛ

№	Үр дүн	Салбар	Шалгуур үзүүлэлт	Хэм-жих нэгж	Суурь түвшин		Зорилгот түвшин				Мэдээллийн үзүүлэлтүүд		
					Он	Түвшин	2025 он	2026 он	2027 он	2028 он	Мэдээллийн эх сурвалж	Мэдээлэл цуглуулах арга зүй	Мэдээлэл цуглуулах давтамж
1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
1		Боловсрол		Хувь	2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	90%	90%	90%			
2		Эрүүл мэнд			2024	89.5%	90%	93%	95%	98%			
3	Нийгмийн салбар тус бүрд хүний нөөцийг удирдан чиглүүлэх бодлого, төлөвлөлтийг хэрэгжүүлсэн байна.	Соёл			2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	90%	90%	90%			
4		Спорт			2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	90%	90%	90%			
5		Хөдөлмөр, нийгмийн хамгаалал			2024	-	Бодлогын баримт бичиг боловсруулсан байна.	90%	90%	90%			

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
6		Нийгмийн салбарын байгууллагууд	Хүний нөөцийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээг тодорхойлох судалгаа хийсэн байгууллага	Тоо	2024	-	7	-	-	-	Салбарын байгууллаг уудын тайлан мэдээ	Тайлан мэдээнд тулгуурлаж гаргах	Жилд 1 удаа
7	Нийгмийн салбарын хүний нөөцийн өнөөгийн болон ирээдүйн хэрэгцээ тодорхойлогдож, чадварлаг албан хаагчдаар хүний нөөцийн бүрдүүлэлт хийгдсэн байна	Боловсрол		Хувь	2024	92%	94%	96%	96%	96%	Боловсролын салбарын хичээлийн жилийн статистик мэдээ	Боловсролын салбарын хичээлийн жилийн статистик мэдээнд үндэслэнэ.	Жилд 1 удаа
8		Эрүүл мэнд	Хүний нөөцийн бүрдүүлэлт	Хувь	2024	80.1%	83%	85%	88%	90%	ЭМГ-ын статистик мэдээ	Эрүүл мэндийн салбарын хүний статистик судалгаанд үндэслэж гаргана.	Жилд 1 удаа
9		Соёл		Тоо	2024	6	-	2	2	2	СУАЖЗГ-ын тайлан мэдээ	Тоон үзүүлэлтэд тулгуурлаж гаргана	Жилд 1 удаа
10		Спорт		Хувь	2024	68%	-	78.6%	89.2%	99.8%	БТСГ-ын тайлан мэдээ	Тоон үзүүлэлтэд тулгуурлаж гаргана	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
11		Хөдөлмөр, халамжийн үйлчилгээ		Тоо	2024	2	-	2	0	-	ХХҮГ-ын тайлан мэдээ	Тоон үзүүлэлтэд тулгуурлаж гаргана	Жилд 1 удаа
12		Нийгмийн даатгал		Тоо	2024	6	-	1	5	0	НДГ-ын тайлан мэдээ	Тоон үзүүлэлтэд тулгуурлаж гаргана	Жилд 1 удаа
13		Хүүхэд, гэр бүл, хөгжил хамгаалал		Тоо	2024	9	3	3	3	0	ХГБХГ-ын тайлан мэдээ	Тоон үзүүлэлтэд тулгуурлаж гаргана	Жилд 1 удаа
14			Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	2024	ЕБС-76.3%	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	2024	ЕБС-76.3%	Багшийн гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	Жилд 1 удаа
15	Нийгмийн салбарын албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэл дээшилж, нийгмийн үйлчилгээ ний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.		9-р ангийн сурагчдын унших чадвар, математикийн хичээлийн гүйцэтгэл	Хувь	2024	Унших чадвар 41.1% Матем атик 33.7%	Унших чадвар 52.0% Математик 35.0%	Унших чадвар 53.0% Матема тик 36.0%	Унших чадвар 54.0% Матема тик 37.0%	Унших чадвар 55.0% Матема тик 38.0%	Үнэлгээний үр дүн	Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулах үнэлгээний гүйцэтгэлийн дунджаас тооцно.	Жилд 1 удаа
16		Боловсрол	Цэцэрлэгийн хүүхдийн сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээний гүйцэтгэл	Хувь	2024	-70.2%	71.0%	71.5%	72.0%	72.5%	Үнэлгээний үр дүн	Боловсролын үнэлгээний төвөөс зохион байгуулах үнэлгээний гүйцэтгэлийн дунджаас тооцно.	Жилд 1 удаа
17			Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	2024	ЕБС-75.8%	Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	2024	ЕБС-75.8%	Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ	Хувь	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
18		Эрүүл мэнд	Застийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт	Хувь	2022	83.9 %	85%	87%	89%	91%	ЭМГ-ын тайлан мэдээ	Эрүүл мэндийн сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтээр тооцно.	Жилд 1 удаа
19			Соёл, урлагийн үйлчилгээ үзүүлсэн иргэдийн нийт хүн амд эзлэх жин	хувь	2024	30%	-	38%	40%	45%	СУАЖЗГ-ын тайлан мэдээ	Салбарын байгууллагуудын үйлчилгээнд хамрагдсан иргэдийн тоог нийт хүн амд харьцуулж тооцно.	Жилд 1 удаа
20		Соёл	Соёлын байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээний дундаж	хувь	2024	94%	95.5%	96%	96.5%	97.0%	СУАЖЗГ-ын тайлан мэдээ	Соёлын 9 байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээний дунджаар тооцно.	Жилд 1 удаа
21			Соёлын салбарын албан хаагчдын мэргэжил, ур чадварын үнэлгээний дундаж	Хувь	2024	-	-	65%	70%	75%	СУАЖЗГ-ын тайлан мэдээ	Үнэлгээнд хамрагдсан 6 байгууллагын албан хаагчдын үнэлгээний дунджаар тооцно.	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
22		Спорт	Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт	Хувь	2024	87%	90%	92%	94%	96%	БТСГ-ын тайлан мэдээ	СУАЖС-ын сайдтай аймгийн Засаг даргын байгуулсан гэрээний хэрэгжилтээр тооцно.	Жилд 1 удаа
23		Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	Засгийн газрын чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хэрэгжилт	Хувь	2024	90.6%	91%	91.5%	92%	92.5%	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын тайлан мэдээ	ХНХ-ын сайдын аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний хэрэгжилтээр тооцно.	Жилд 1 удаа
24	Нийгмийн салбарын албан хаагчдын ажлын бүтээмж, гүйцэтгэл дээшилж, нийгмийн үйлчилгээ ний чанар, хүртээмж нэмэгдсэн байна.	Нийгмийн салбарын байгууллаг ууд	Албан хаагчдын сэтгэл ханамж Хамт олны дунд зэрэг уур амьсгал бүрдүүлэх чиглэлээр нийгмийн салбарын байгууллага тус бүрт хэрэгжсэн төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	-	Судалгаа хийж суурь түвшинг тодорхойлох	Хувь нэмэгдсэн байна.	Хувь нэмэгдсэн байна.	Хувь нэмэгдсэн байна.	Хийдсэн судалгааны тайлан	Судалгааны тайланд үндэслэж гаргана.	Жилд 1 удаа
25			Байгууллага тус бүрт хэрэгжсэн төлөвлөгөөний хэрэгжилт	Хувь	2024	-	-	100%	100%	100%	Байгууллаг уудын тайлан мэдээ	Тайлан мэдээнд тулгуурлаж гаргана.	Жилд 1 удаа

1	2	3	4	5	6	7	8	9	10	11	12	13	14
26	Нийгмийн салбарын байгууллагуудад чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байна.	Нийгмийн салбарын байгууллагууд	Чанарын удирдлагын тогтолцоо нэвтрүүлсэн байгууллага	Тоо	2024	6	3	7	10	15	Байгууллагуудын тайлан мэдээ	Тоон үзүүлэлтэд тулгуурлаж гаргана	Жилд 1 удаа

ОРХОН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР